



MNAS AC12

МОНГОЛ УЛСЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

БҮТЭЭГДЭХҮҮН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР

Нэгдсэн үндэсний гудамж 5/1, 3Г-ын II байр
Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: (976) 77073689
Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

ХЭВЛЭСЭН ОГНОО:
18.12.2015

ӨӨРЧЛӨЛТ NO: 02
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 02.12.2024

0 Оршил

Аж үйлдвэрийн салбар, менежментийн тогтолцоо, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Монгол Улсын засгийн газар болон Үндэсний итгэмжлэлийн төв хамтарч менежментийн тогтолцоо, бүтээгдэхүүний баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бий болгохоор ажиллаж байгаа билээ.

MNAS-аас гаргасан Бүтээгдэхүүн баталгаажуулалтын эхний шалгуурыг Монгол Улсад явагдаж буй баталгаажуулалтын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, гадаад улс болон бүс нутаг, олон улсын гэрээнд нэгдэх зорилгоор ISO/IEC 17065:2013 стандартын дагуу боловсруулсан. Итгэмжлэлийн шалгуурыг IAF/APAC-аас шинээр хэвлэгдсэн стандарт, заавал дагаж мөрдөх баримт бичгийн лавлагааг тусгах зорилгоор тогтмол шинэчилдэг.

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь Бүтээгдэхүүн баталгаажуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хөндлөнгийн байгууллагыг MNAS-аас бүтээгдэхүүн баталгаажуулалтын үйл ажиллагааг явуулах чадвартай, найдвартай гэж үнэлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлно.

2 Шалгуур

- Бүтээгдэхүүний баталгаажуулалт хийх итгэмжлэл хүссэн Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17065 “Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага” стандартад заасан шаардлагуудыг хангах үүрэгтэй.
- Баталгаажуулалтын схемийг ISO/IEC 17067 стандарт, IAF MD 25 баримт бичиг болон MNAS-аас баталсан бусад баримт бичгийн дагуу бүтээгдэхүүний баталгаажуулалтын шаардлагад дүйцэхүйц байдлаар үнэлнэ.

Тайлбар: MNAS нь Бүтээгдэхүүний баталгаажуулалтын талаархи IAF/APAC-аас заавал дагаж мөрдөх баримт бичиг гарч эсхүл шинэчлэгдэх бүрт итгэмжлэлийн шалгуурын нэг хэсэг болгоно.

- ISO/IEC 17065 болон бусад холбогдох ISO/IEC 17067, ISO/IEC 17028 зэрэг стандартын хувь, хуулбарыг Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)-аас авч болно.

3 ISO/IEC 17065 стандартын шаардлагын удирдамж

MNAS нь ISO/IEC 17065 стандартын шаардлага болон IAF-н заавал мөрдөх баримт бичгүүдийг нэмэлт шалгуурын баримт бичгээр ашиглана. Итгэмжлэлийн шалгуурын талаар тодруулга хэрэгтэй бол MNAS нэмэлт тайлбар өгнө.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC12	Бүтээгдэхүүн баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 18.12.2015	Өөрчлөлт No:02	Хуудас: 1/3
	Өөрчлөлтийн огноо: 07.07.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Тайлбар: IAF-н заавал мөрдөх баримт бичгийг IAF цахим хуудаснаас англи, MNAS цахим хуудаснаас монгол хэлээр тус тус үнэгүй татаж авах боломжтой.

4 Итгэмжлэлийн хүрээ

MNAS нь Бүтээгдэхүүн баталгаажуулалтын итгэмжлэлийн хамрах хүрээг бүтээгдэхүүний стандартад үндэслэн тодорхойлсон. Зохицуулагч эсвэл схем эзэмшигч нь тусгай хамрах хүрээг тодорхойлсон бол итгэмжлэлийг хүрээг тус хүрээний дагуу олгож болно.

Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлэлийн хүрээнд хамаарах бүх бүтээгдэхүүний стандарт, баримт бичиг, схемийн жагсаалтыг хөтөлнө. Энэ жагсаалтыг Баримт бичгийн хяналтын хүрээнд хадгалж, хяналт тавина. Тус хяналттай баримт бичгийн түгээлт, тараалтад MNAS-ийг оруулна.

5 Баталгаажуулалтын байгууллага (ББ)-ын чадамж

MNAS-ийн итгэмжлэл нь тухайн баталгаажуулалтын байгууллага тодорхой хүрээнд Бүтээгдэхүүний баталгаажуулал хийх чадвартайг харуулна. Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлүүлэх техникийн хүрээгээ тодорхойлж, тухайн хүрээнд баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулах чадвартайгаа батлах үүрэгтэй.

Баталгаажуулалтын байгууллага нь аудитор, шинжээчдийнхээ анхдагч үнэлгээ, ур чадвар, гүйцэтгэл, мониторингийн талаар ISO/IEC 17065 болон ISO 19011 стандартад үндэслэсэн журамтай байна. Баталгаажуулалтын байгууллага нь техникийн тодорхой хүрээнд аудитор / шинжээч бэлтгэх журамтай байна.

6 Баталгаажуулалтын байгууллагын Аудит хийх хугацаа

Хэрэв баталгаажуулалтын схемийн шаардлагаар өргөдөл гаргагч эсхүл гэрчилгээжсэн байгууллагын ажлын байранд аудит, тохирлын үнэлгээ хийхэд шаардлагатай хүн өдрийг тооцоолох бол баталгаажуулах байгууллага нь тус тооцооллын зөв гэдгийг батална.

---xxx---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC12	Бүтээгдэхүүн баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 18.12.2015	Өөрчлөлт No:02	Хуудас: 2/3
	Өөрчлөлтийн огноо: 07.07.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлт №.	Огноо	Баталсан	Гарсан өөрчлөлт
01	2021.01.20	MNAS дарга	Дахин хянаж, баталсан.
02	2024.07.07	MNAS дарга	IAF MD 25-ын хэрэгжилтийг хангах хүрээнд шинэчилсэн.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC12	Бүтээгдэхүүн баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 18.12.2015	Өөрчлөлт No:02	Хуудас: 3/3
	Өөрчлөлтийн огноо: 07.07.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ